



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 05 сарын 24 өдөр

Дугаар А/15

Шивээговь сум

Эд хөрөнгийн тооллого зохион байгуулах
комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1, 72.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2, 12.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.Байгууллагын эд хөрөнгийн 2024 оны эхний хагас жилийн тооллогыг 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдрөөс 06 дугаар сарын 05-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2.Байгууллагын эд хөрөнгийн тооллогыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:

Л.Бадамханд
(1 дүгээр багийн Засаг дарга)

Гишүүн:

Н.Амаржаргал
(Мэдээллийн технологи, олон нийттэй харилцах ажилтан)

Л.Туяа
(Ахлах нягтлан бодогч)

Л.Цэнд-Аюуш
(Нягтлан бодогч)

Н.Нямдорж
(Жолооч)

3.Байгууллагын эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг газар дээр нь үзэж эргэлтийн болон үндсэн хөрөнгийн шилжилт хөдөлгөөн элэгдэл хорогдол, актлан устгах тухай дүгнэлт, тайланг гарган байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлд танилцуулахыг комиссын дарга (Л.Бадамханд)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ОТГОНЖАРГАЛ